

МОНГОЛ УЛСЫН БҮС НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙГ КЛАСТЕРЫН ЗАГВАРААР ХӨГЖҮҮЛЭХ АСУУДАЛ

*А.Даваасүрэн¹
Б.Хүрэлбаатар²*

Хураангуй: Энэхүү өгүүлэлд Монгол Улсын бүс нутгийн эдийн засгийн бодлогын хэрэгжилтэд үнэлэлт өгч, бүс нутагт жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх төрийн бодлогын сул талуудыг тодорхойлж, цаашид бүс нутгийн эдийн засгийн бодлогын арга хэрэгсэл, механизмуудыг бүрэн ашиглах шаардлагатай байгааг дурьдаж, эдийн засгийн зохицуулалтын шууд ба шууд бус арга хэрэгсэлүүдийн онцлогыг бичив. Чингэхдээ Монгол Улсын нөхцөлд эдийн засгийн арга хэрэгсэлүүд харьцангуй хязгаарлагдмал учир эдийн засгийг зохицуулахдаа захиргааны арга хэрэгсэлүүдийг ашиглахыг цохон тэмдэглэж, гадаадын өрсөлдөөнөөс үндэсний үйлдвэрлэгчдийг хамгаалах ёстой гадаад худалдааны бодлого бараг хэрэгжихгүй байгааг тайлбарлав. Бидний хийсэн судалгаа бүс нутагт жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх төрийн бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, бүс нутагт инноваци – аж үйлдвэрийн кластеруудыг байгуулах замаар бүс нутгийн эдийн засгийг удирдаж улс орны эдийн засгийн хөгжлийн загварт тулгуурласан урт хугацааны стратегийг боловсруулах шаардлагатай бөгөөд эдгээр кластерууд нь тухайн бүсэд байгаа үйлдвэрлэх хүчний нөөцийн давуу тал дээр тулгуурлан дагнах, төрөлжих замаар хөгжих ёстой гэсэн үр дүнд хүрэв.

Түлхүүр үгс: Монгол Улс, бүс нутаг, жижиг дунд үйлдвэр, бүс нутгийн эдийн засгийн бодлогын арга хэрэгсэл, механизмууд, хууль эрх зүй, инноваци – аж үйлдвэрийн кластерууд.

¹ А.Даваасүрэн, ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн Олон улсын эрх зүй, эдийн засгийн салбарын эрхлэгч, профессор доктор Sc.D. Утас: +976 91910523, e-mail: davaasuren13@yahoo.com

² Б.Хүрэлбаатар, ОХУ-ын Эрхүү хотын Байгалийн улсын их сургуулийн татварын тэнхмийн аспирант. Утас: +976 99115354, e-mail: khurlee_mta@yahoo.com

*Монгол Улсын Бүс Нутгийн Эдийн Засгийг Кластерын
Загвараар Хөгжүүлэх Асуудал*

Дэлхийн тэргүүлэх хөгжилтэй улс орнуудад бүс нутгийн хөгжлийн асуудлыг шинжлэх ухааны үүднээс судлаж, урт хугацааны стратегийн төлөвлөлтийг хийж, удирдахад ихээхэн ач холбогдол өгөх болжээ. Ингэхдээ төр, засгийн газрын буюу нийт үндэстний ашиг сонирхолыг бүс нутгийнхтай уялдуулан эдийн засаг дахь байгаль, нийгэм, үйлдвэрлэлийн нөөцүүдийн зохистой харьцааг хангахад ихээхэн анхаарч байна.

Бидний хийсэн судалгаа Монгол Улсын үйлдвэрлэх хүчний нөөцүүдийн 80 гаруй хувь нь зөвхөн Улаанбаатарын бүсэд төвлөрсөн байгаа нь бусад бүсүүдэд аж ахуй болон үйлдвэрлэлийн дампуурал, байгаль экологийн доройтол, ажилгүйдэл, ядуурлыг нэмэгдүүлэх үндсэн нөхцөл болж байна гэсэн дүгнэлтэд хүрэв. Энэ нь төр, засгийн зүгээс бүсийн эдийн засгийн хөгжлийн бодлого, стратегиа эргэж харах, бүс нутгийн нийгэм, эдийн засгийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд урт хугацаанд судалгаанд суурилсан, залгамж шинж чанартай, тогтвортой бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Төрийн зүгээс бүсүүдийн эдийн засгийн зохицуулах зорилго нь хууль эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх, бүс нутагт жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд мөнгө, зээлийн болон татвар, төсвийн зэрэг макро эдийн засгийн үндсэн бодлогоор дэмжлэг үзүүлэх явдал юм. Түүнчлэн гадаад худалдааны бодлого зохицуулалтын үр нөлөөг эрс дээшлүүлэх, түүний дотор тарифын бус зохицуулалтын олон хэрэгслийг бүрэн ашиглах, бүс нутагт хөгжүүлэх салбарын болон өмч, хөрөнгө, үнэ тариф, хөрөнгө оруулалт, инновацийн бодлогын арга хэрэгсэлүүдийг хооронд нь уялдаатай, хосолсон ба дагнасан хэлбэрээр бүсүүдийн нийгэм, эдийн засгийн тогтвортой, давшингуй, үр дүнтэй хөгжлийг хангах шаардлагатай байна.

Онолын хувьд төрийн зүгээс хэрэгжүүлж буй бүс нутгийн эдийн засгийг зохицуулалтыг захиргааны болон эдийн засгийн зохицуулалт гэж ангилдаг боловч тэдгээрийн үйлчлэл, үр нөлөө төдийлөн хүчтэй харагдаж, солбилцож чаддаггүй байна. Төр засгийн сүр хүч дээр тулгуурласан захиргааны арга хэрэгсэлүүдэд янз бүрийн зөвшөөрөл, хориг, албадлага гэх мэт багтана. Тухайлбал, төр, засгийн байгууллагын зүгээс макро түвшинд өмч хувьчлалын үйл явцыг

зохицуулах, гадаадын хөрөнгө оруулалтыг эдийн засгийн тэргүүлэх салбар руу чиглүүлэх, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, мезо түвшинд бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжил, ажил эрхлэлтэд дэмжлэг болохуйц нийгмийн шинж чанартай урамшуулал, хөнгөлөлт, чөлөөлөлтийг үзүүлэх, орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хот хөдөөгийн иргэдийн нүүдэл суудлыг зохицуулах, микро түвшинд зарим нэгэн этгээдэд хуулиар тогтоогдсон хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд албадлагын арга хэрэгсэлийг ашиглах зэрэг болно. Захиргааны зохицуулалтын арга хэрэгсэлүүд нь дангаараа бүс нутгийн нөхөн үйлдвэрлэлийн үйл явцын тасралтгүй болон үр ашигтай байдлыг хангаж чадахгүй учир түүнийг эдийн засгийн зохицуулалтын арга механизмуудтай хослуульж ашиглахад илүү үр дүнгээ өгдөг байна.

Эдийн засгийн зохицуулалтын арга механизмууд нь бүс нутаг дахь үйлдвэрлэл эрхлэгчдийн эдийн засгийн ашиг сонирхолыг урамшуулах зорилгоор бага хүүтэй, урт хугацаатай хөнгөлөлтэй зээл, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, санхүүгийн татаас, дэмжлэг, гадаад худалдааны таатай нөхцлийг бүрдүүлэх замаар гадны өрсөлдөөнөөс үндэсний үйлдвэрлэгчдийг хамгаалж, бүс нутгийн тасралтгүй нөхөн үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэхэд чиглэгддэг. Дэлхийн ихэнхи оронд гадаад худалдаандаа тарифын бус хориг саадыг өргөнөөр ашиглаж байгаа туршлага байдаг. Үүнд импортын тарифыг нэмэхгүйгээр зарим төрлийн бараа, бүтээгдэхүүн, машин, техник, хүнс, хөдөө аж ахуй, цахилгаан барааны импортыг лицензжүүлэх, квотжуулах замаар хураамжийн орлогоор нь үндэсний үйлдвэрүүдэд дэмжлэг үзүүлж байна.

Захиргааны зохицуулалтаас эдийн засгийн зохицуулалтын үр дүн их бөгөөд үндсэн зорилго нь эх орны үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагуудын эдийн засгийн ашиг сонирхолыг хамгаалахад чиглэгдэх ёстой ба эдгээр арга механизмуудыг хэрхэн зохистой ашиглах, бүс нутгийн эдийн засагт төрийн зүгээс ямар арга хэрэгсэлийг ашиглаж, яаж оролцохоос хамаарч бүс нутгийн жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн үйл ажиллагаа шалтгаалах ба цаашлаад улс орны хэмжээнд ажлын байр шинээр бий болгох, ядуурал, ажилгүйдлыг бууруулах зэрэг нийгэм, эдийн засгийн хөгжлийн асуудлуудыг цогцоор амжилттай шийдэх боломжтой юм.

*Монгол Улсын Бүс Нутгийн Эдийн Засгийг Кластерын
Загвараар Хөгжүүлэх Асуудал*

Монгол Улсын нөхцөлд бүс нутагт жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх шаардлагатай дараах тэргүүлэх салбаруудыг тодорхойлж байна. Үүнд:

- Мал аж ахуйн түүхий эдээр эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боловсруулах салбар;
- Газар тариалангын түүхий эдийг боловсруулж, эх орны хүнсний бүтээгдэхүүнээр хүн амыг хангах хүнсний салбар;
- Уул уурхайн түүхий эдийг боловсруулж хүн амын өргөн хэрэглээний бараа болон хөдөлмөрийн багаж зэмсэг үйлдвэрлэх боловсруулах салбар;
- Бүс нутгийн жижиг дунд үйлдвэрүүдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд борлуулахад төрийн зүгээс дэмжлэг үзүүлэх гадаад худалдааны салбар гэх мэт.

Монголын нөхцөлд төрийн зүгээс эдийн засгийн зохицуулалтын дээрхи арга механизмуудыг бүрэн ашиглаж чадахгүй байгаагаас гадна бүс нутгийн жижиг дунд үйлдвэрүүдийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль, эрх зүйн актууд нь өөр хоорондоо зөрчилтэй бөгөөд боловсронгуй бус байна.

Иймд Монгол Улсад төрийн зүгээс бүс нутгийн эдийн засгийн урт хугацааны зохицуулалтыг хамгийн үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд дараах бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Захиргааны зохицуулалтын арга механизмуудыг эдийн засгийн зохицуулалтын арга механизмтай хослуулан бие биенээ нөхсөн хэлбэрээр үр ашигтай ашиглах;
- Бүс нутгийн богино, дунд, урт хугацааны нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого, стратегийг шинжлэх ухааны үндэстэй боловсруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- Эдийн засгийг захиргааны аргаар удирдах арга хэрэгсэлүүдийн нэг чухал хэсэг болсон төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн газруудын үйл ажиллагаа, тэдгээрийн худалдан авалтад бүс нутгийн жижиг дунд үйлдвэрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хамруулахад дэмжлэг үзүүлэх;

- Бүс нутгийн жижиг дунд үйлдвэрийн үйл ажиллагаанд нийгмийн шинж чанартай хөнгөлөлт чөлөөлөлт, урамшуулалыг (ажлын байр хадгалсаны урамшуулал, орон сууц, дулаан, цахилгаан, усны хөнгөлөлт, цалингийн нэмэгдэл, сургалтын төлбөрөөс хөнгөлөх, ээлжийн амралтын зардлыг төр даах гэх мэт) олгох;
- Өндөр хөгжилтэй орны шинэ техник, технологийг эзэмших, тэдгээрийг нутагшуулж буй эх орны аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг урамшуулсан гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын болон инновацийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх;
- Эдийн засгийн салбарын бодлогыг үнэ тарифын, өмч, өрийн болон гадаадын тусламжийн бодлогын хэрэгслүүдтэй уялдуулан ашиглаж аж үйлдвэржилтийг тууштай дэмжсэн бодлого хэрэгжүүлэх;
- Үнэ тарифын бодлогыг уян хатан болгож эрчим хүч, дулаан үйлдвэрлэл, усан хангамжийн үнэ бүрдэлтийг эдийн засгийн салбар, бүс нутаг болон цаг хугацааны хувьд ялгавартай тогтоох;
- Бараа, бүтээгдэхүүн, санхүүгийн болон ажиллах хүчний зах зээлд төрийн хяналт шалгалт, стандартчлалын үүргийг гүйцэтгэж буй төрийн байгууллагуудын үйл ажиллагааг боловсронгуй болгох;
- Төрийн байгууллагын зүгээс аж ахуйн болон гадаад худалдааны лиценз, квот олгох үйл явцыг шударга, авлига, хээл хахуулиас ангид байлгах.

Бүс нутгийн эдийн засгийг тогтвортой бодлого, зохицуулалтын арга хэрэгслүүдээр дэмжихийн зэрэгцээ шинжлэх ухааны судалгаан дээр суурилсан урт хугацааны төлөвлөлт, удирдлагын системийг нэвтрүүлэх шаардлагатай байна.


*Монгол Улсын Бүс Нутгийн Эдийн Засгийг Кластерын
Загвараар Хөгжүүлэх Асуудал*



Зураг 1-ээс юуны өмнө улс орны нийгэм, эдийн засгийн бодит нөхцөл байдалд үнэлгээ өгч, давуу болон сул тал, үйлдвэрлэлийн нөөцийн байршилт, ашиглалтад шинжилгээ хийж, хөгжлийн хоцрогдолд нөлөөлж буй гадаад, дотоод орчинг судалсаны үндсэн дээр хөгжлийн хэтийн таамаглал (прогноз) дэвшүүлж, цаашид улс орон болон түүний тодорхой бүсүүдийг хөгжүүлэх эдийн засаг, аж үйлдвэрийн хөгжлийн богино, дунд, урт хугацааны стратегийг боловсруулж олон нийт болон эрдэмтэн мэргэдээр хэлэлцүүлж, саналыг нь тусгасаны үндсэн дээр ямар стратегийн хувилбараар улс орон, түүний бүсүүдийг хөгжүүлэхэд захиргааны болон эдийн засгийн бодлогын ямар хэрэгсэлүүдийг хэрхэн яаж ашиглахыг тодорхойлж, хууль тогтоох дээд байгууллагаар батлуулсаны дараа хэрэгжилтийг зохион байгуулах, дараа нь явцад хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийн явцад илэрсэн алдаа, шалгуур, үзүүлэлтээс хазайсан шалтгааныг тодорхойлж залруулга хийх замаар урт хугацаанд улс орон болон түүний бүс нутгийн эдийн

засгийн хөгжлийг удирддаг олон улсын туршлага тодорхой харагдаж байна.

Түүнээс гадна манай улсад кластерт суурилсан загвараар бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг хурдасгах боломжтой гэж бид үзэж байна. Ингэхдээ Монгол Улсын нутаг дэвсгэр дээр инноваци-аж үйлдвэрийн кластеруудыг байгуулах замаар бүс бүрт байгаа байгалийн баялаг, ажиллах хүч, санхүү, дэд бүтэц, шинжлэх ухаан, боловсрол, техник, технологийн хөгжлийн давуу тал дээр тулгуурлан тухайн бүс тодорхой төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл дээр дагнаж төрөлжих маягаар хөгжих боломжтой юм. Монгол Улсад байгуулагдах инноваци-аж үйлдвэрийн кластерыг зураг 2-оос харна уу.



Зураг 2. Монгол Улсад инноваци - аж үйлдвэрийн кластеруудыг байгуулах зураглал

Инноваци - аж үйлдвэрийн кластеруудыг байгуулах эхний үед төрийн зүгээс аж ахуйн нэгж, компани, шинжлэх ухаан, боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, тэдгээрийн хоорондын холбоосыг санхүүжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх ёстой. Үүний тулд төр, засгийн газар нь урт хугацаатай, хямд санхүүгийн эх үүсвэрийг олон улсын санхүүгийн болон донор улсуудын зүгээс татан төвлөрүүлэх, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх санг байгуулах,

*Монгол Улсын Бүс Нутгийн Эдийн Засгийг Кластерын
Загвараар Хөгжүүлэх Асуудал*

Үйлдвэрлэлд технологи дамжуулах болон инновацийн шинэ бүтээгдэхүүн бий болгох зориулалттай шинжилгээ, судалгааны ажлыг бүх талаар дэмжихэд ихээхэн анхаарах ёстой. Ингэхдээ инноваци-аж үйлдвэрийн кластеруудын дэргэд инженерийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг байгуулах замаар мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх шаардлагатай. Харин үндэсний эрдэм шинжилгээ судалгааны байгууллага, хүрээлэнгүүд, лаборатори, инженерийн төвүүд тэргүүн туршлага, шинэлэг санаа, технологийг бий болгож, тэдгээрийг аж үйлдвэрийн салбарт дамжин нэвтэрүүлэхэд төр бүх эрсдэлийг өөртөө үүрэх ёстой бөгөөд кластеруудын үйл ажиллагаа жигдэрсний дараа төрийн нуруун дээр ирэх санхүүгийн болон зохион байгуулалтын ачаалал буурдаг туршлага олон улсад байна.

Ийнхүү бүс нутгийн кластер дээр суурилсан Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн загвар нь бүсүүдийн хувьд санхүү, эдийн засгийн бие даасан байдлыг хангах, бүс нутгуудад эдийн засгийн хувьд тэгш тэнцүү урт хугацааны хөгжих боломжийг олгож, төвөөс хамаарах хамаарал багасах, кластерт багтаж буй жижиг дунд, том компаниуд өөрийнхөө үйлдвэрлэлийн нөөц, чадамжаа инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд төвлөрүүлж, цаашлаад гадаад, дотоод зах зээлд гаргах бололцоотой болно хэмээн бид үзэж байна.

Ашигласан материал

1. Постановление Парламента Монголии № 57. “О концепции регионального развития Монголии”, утвержденное 2001г.
2. Афанасьев М. и Мясникова Л. Мировая конкуренция и кластеризация экономики. – Вопросы экономики. – 2005. - № 4. - С.75-86.
3. Воронов А. Кластеры - новая форма самоорганизации промышленности в условиях конкуренции / А. Воронов // Маркетинг. - 2002. -№ 5 (66). - 36-44.
4. Самаруха В.И., Краснова Т.Г., Плотникова Т.Н. Региональная экономика: стратегические аспекты развития Сибирского округа. – Иркутск: Изд-во БГУЭП, 2009. – С. 52.
5. Самаруха В.И., Николаева И.С.Формирование интегрированных кластеров в регионе. – Иркутск: Изд-во БГУЭП, 2012. – С. 41–42.
6. Самаруха В.И., Бураев Ф.В. Развитие межотраслевого комплекса в аграрном регионе. – Иркутск: Изд-во БГУЭП, 2006. – С. 13–32.
7. Ялов Д.А. Кластерный подход как технология управления региональным экономическим развитием / [http: www.govirk.ru](http://www.govirk.ru), Иркутск, 2006.
8. Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос жил тутам гаргадаг статистикийн эмхэтгэл, 2005-2015 он.